



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.05.12 № 01/378
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЦЭЦГЭЭГИЙН
ДАВААХҮҮ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Цэцгээгийн Даваахүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага нь Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Цэцгээгийн Даваахүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050” болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Цэцгээгийн Даваахүүгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сонгуулийн хороонд
Хавсралт хуудастай.

| | | |
|-----------------------------|-----------------------------------------------------------------------------------|----------------|
| ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР |  | А.ЭРДЭНЭБААТАР |
| ХЯНАСАН: | | |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | | Б.ТЭГШДЭЛГЭР |
| БОЛОВСРУУЛСАН: | | |
| АХЛАХ АУДИТОР | | З.ДАВААДОРЖ |



АЙМАГ НИЙСЛЭЛ СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МУХАР ХӨНДИЙ БАГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЦЭЦЭГЭЭ ОВОГТОЙ ДАВААХҮҮГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛАГА

1. Ц.ДАВААХҮҮ
2. ТӨРСӨН ОН САР- 1989.03.20
3. УРГИЙН ОВОГ – ХОНИН ОНХОД
4. ТӨГССӨН СУРГУУЛЬ – ТОСОНЦЭНГЭЛ СУМ ЕБС БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ 2007 ОНД
5. БОЛОВСРОЛ –ДЭЭД
6. МЭРГЭЖИЛ – СОЁЛЫН МЕНЕЖМЕНТ
7. ТӨГССӨН СУРГУУЛЬ - ХУИС-ЫН ХАРЪЯА ДАЛАЙВАН ДЭЭД СУРГУУЛЬ
8. АМ БҮЛ - НӨХӨР 4 ХҮХЭДТЭЙ
9. ГЭРИЙН ХАЯГ – ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН 5-Р БАГ
10. ОДОО ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ – ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН СОЁЛЫНТӨВ СОЁЛЫН ӨВ ХАРИУЦСАН АЖИЛТАН

ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэр хэрэгжилтийг ханган ажиллахын тулд эрх хэмжээний хүрээнд шийдвэр гарган санал хүсэлтээ дамжуулан ажиллана.
2. Жилд 1 удаа иргэдээ сонсьё аян хурал хийнэ.
3. Байгаль орчны алба болон иргэдтэй хамтран эх нутгаа хайрлъя аян хөтөлбөрт үйл ажиллагаа зохион байгуулна.
4. Монгол үндэсний өв соёл, ёс заншил, зан үйлийг иргэдэд сурталчилах өвлүүлэн үлдээх бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулах.
5. Төрийн үйлчилгээг ил тод , шудрага, хариуцлагатай болгоход санал санаачлага гарган багийн ард иргэдэд мэдээлэн хамтран ажиллах
6. Суманд хэрэгжиж буй төсөл,хөтөлбөр , нийгмийн халамжийн үйлчилгээг зохих эздэд нь хүртээх талаар идэвхи санаачлага гарган хамтран ажиллана.
7. Багийн иргэдийг хөгжүүлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Бид хамтдаа” урлагийн наадам зохион байгуулах
8. Цагдаагийн байгууллага болон бүхий л шатны төрийн байгууллагуудтай хамтран багийн иргэдийн дундах архидан согтуурах , гэр бүлийн хүчирхийлэл, хууль бус үйлдлүүдийн судалгаа гарган тэдгээр хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох ажил үйлчилгээний мэдээлэл сургалт зохион байгуулан хамтран ажиллина.
9. Төрийн ажил үйлчилгээг багт тэгш хүртээмжтэй хүргэх мэдээлэлтэй байх тал дээр анхаарч ажиллана.
10. Малчдад нэн шаардлагатай байгаа тусламж ажил үйлчилгээний судалгааг багийн даргатай хамтран гаргана.
11. Багийн соёлын төвд шинээр сандалтай болгох олон нийтийн дэмжлэгээр ажлыг зохион байгуулна.
12. Багийн хүүхэд багачууд иргэдэд тулгарч буй асуудлын судалгаа гарган шийдвэрлэх тал дээр хариуцах шатны байгууллагуудтай хамтран шийдвэрлэж ажиллана.

